

22



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 08 сарын 01 өдөр

Дугаар 04

Номгон

“Жаргалтай амьдрал сэтгэц, нийгмийн сэргээн засах эмчилгээний төв” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрыг байгуулж, дүрмийг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18.1.3-ын “ж”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4, 77.3, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн II хуралдаанаар батлагдсан “Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2 дугаар бүлгийн 2.1.2, 2.2.2, 4 дүгээр бүлгийн 4.4.1.1, “Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2.2.2, 3.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн хэмжээнд архинд донтох эмгэгийн тусламж үйлчилгээ үзүүлж, сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулах чиг үүрэг бүхий “Жаргалтай амьдрал сэтгэц, нийгмийн сэргээн засах эмчилгээний төв” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрыг үүсгэн байгуулсугай.

2. “Жаргалтай амьдрал сэтгэц, нийгмийн сэргээн засах эмчилгээний төв” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын дүрмийг хавсралтаар баталсугай.

3. Аймгийн Засаг дарга /Д.Мөнхсайхан/-д ДААЛГАХ нь:

3.1. “Жаргалтай амьдрал сэтгэц, нийгмийн сэргээн засах эмчилгээний төв” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрыг дүрмийн дагуу ажиллахад удирдлага зохион байгуулалтаар ханган ажилласугай.

3.2. Цаашид улсын төсвөөс санхүүжих, эрүүл мэндийн даатгалд хамруулах, бие даан ажиллах нөхцөл боломжийг судлан шийдвэрлэж, жил бүрийн үйл ажиллагааны тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулсугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Байгальмаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Э.ЭНХБАТ

0121023

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2021 оны 02 дугаар сарын 01-ний  
өдрийн 24 дүгээр тогтоолын хавсралт

**"ЖАРГАЛТАЙ АМЬДРАЛ СЭТГЭЦ, НИЙГМИЙН  
СЭРГЭЭН ЗАСАХ ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВ" ОРОН НУТГИЙН ӨМЧИТ  
АЖ АХУЙН ТООЦООТОЙ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ДҮРЭМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. "Жаргалтай амьдрал сэтгэц, нийгмийн сэргээн засах эмчилгээний төв" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар нь сэтгэцийн сэргээн засах эмчилгээний чиглэлээр аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах, тусламж үйлчилгээ үзүүлэх байгууллага юм.

1.2. Газар нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүл мэндийн тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомж, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, тушаал, дүрэм, заавар, стандарт, удирдамжийг мөрдлөг болгон ажиллана.

1.3. Газар нь сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, олон нийтийг татан оролцуулж хамтран хэрэгжүүлнэ.

1.4. Аймгийн Засаг дарга нь газрын даргыг хууль тогтоомжид заасны дагуу томилж, чөлөөлөх бүрэн эрхтэй.

1.5. Газар нь чиглэлийн хүрээнд алсын хараа, эрхэм зорилго, байгууллагын стратеги төлөвлөгөөтэй байна.

1.6. Газар нь Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, тусгай мэргэжлийн төв болон төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг зэргээс холбогдох чиг үүргийн хүрээнд мэргэжил арга зүйгээр хангагдана.

1.7. Газар нь бүтэц, зохион байгуулалт болон хүний нөөц, санхүүжилтийг харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын тоо, төвлөрлийг харгалзан зохицуулна.

1.8. Газар нь тогтоосон журмаар хийгдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, санхүүгийн харилцах данстай байна. Мөн өөрийн онцлогийг илэрхийлсэн бэлгэдэлтэй байна.

1.9. "Жаргалтай амьдрал сэтгэц, нийгмийн сэргээн засах эмчилгээний төв" ОНӨААТҮГ нь Баянхонгор аймаг, Дуурсах баг гэсэн хаягтай байна.

1.10. Төвийн нэрийг англи хэл дээр "Mental and society rehabilitation center" гэж орчуулна

1.11. Энэхүү дүрмийг "Жаргалтай амьдрал сэтгэц, нийгмийн сэргээн засах

эмчилгээний төв" ОНӨААТҮГ-ын удирдлага, албан тушаалтан, ажилтан заавал дагаж мөрдөнө.

1.12. Дүрмийн хэрэгжилтэд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хяналт тавина.

### **Хоёр. Газрын зорилго, чиг үүрэг**

2.1. Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд хүн амыг архидан согтуурах, мансуурах, тоглоомд донтох, стресст өртөх зэрэг сэтгэцийн эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг хүчин зүйлсээс урьдчилан сэргийлэх, эмчлэх, эрүүл мэндийн боловсрол олгох, сэтгэцийн өвчлөл, нас баралт түүний шалтгаант эмгэг, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах судлах үйл ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлнэ.

2.2. Харьяа нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, хүн амын эрүүл мэндийн талаарх хэрэгцээ, амьдралын дадал хэвшил, хандлагыг судлан тандах, эрүүл мэндийн мэдээлэл, сургалтыг зохион байгуулах, нэвтрүүлэг бэлтгэх, нийтлэн түгээх, эрүүл зан үйл, аж төрөх ёсыг хэвшүүлэх үйл ажиллагаа, арга хэмжээнд салбар дундын хамтын ажиллагааг хангаж, хэрэгжүүлнэ.

### **Гурав. Газрын үйл ажиллагааны зарчим**

3.1. Үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтлана. Үүнд:

3.1.1 Үйлчлүүлэгчийг дээдлэх;

3.1.2 Үйлчлүүлэгч бүрт эрх тэгш хандах;

3.1.3 Хувь хүний эрх ашиг, нэр төрийг хүндэтгэн нууцлалыг сахих;

3.1.4 Тусламж, үйлчилгээ, орчны чанар, аюулгүй байдлыг хангах;

3.1.5 Тусламж, үйлчилгээтэй холбоотой шийдвэрийг нотолгоонд суурилан гаргах;

3.1.6 Тусламж, үйлчилгээг үйлчлүүлэгчдэд чирэгдэлгүй, шуурхай хүргэх;

3.1.7 Ил тод, нээлттэй байж үйлчлүүлэгчдийг шаардлагатай мэдээллээр хангах;

3.1.8 Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөх

3.2 Үйлчлүүлэгчийн үүрэг Үүнд:

3.2.1 Эрүүл мэндийн боловсрол эзэмших, амьдралын зөв дадал хэвшилтэй болох, эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар зохиож байгаа ажилд оролцох;

3.2.2 Халдварт өвчин тархахаас сэргийлж, эрүүл мэндийн байгууллагын дэглэмийг сахиж мөрдөх;

3.2.3 Хүний эрүүл мэнд болон нийгэмд аюул бүхий өвчин, хордлого, осол, гэмтэл, орчны сөрөг хүчин зүйлийн талаар тухайн байгууллагад цаг тухайд нь мэдээлэх;

3.2.4 Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлт зан үйлээс татгалзах, сэргийлэх, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх үйлдлийг таслан зогсоох талаарх эрүүл мэндийн байгууллагын шаардлагыг биелүүлэх;

3.2.5 Эрүүл мэндийн ажилтныг ажил үүргээ гүйцэтгэж байхад саад учруулахгүй, нэр хүнд, бие махбодид нь халдахгүй байх;

3.2.6 Эрүүл мэндийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй, эрүүл мэндийн байгууллагын нэр хүндийг унагаах зорилго бүхий ташаа мэдээлэл өгөхгүй байх

#### Дөрөв. Газрын эрх, үүрэг

4.1. Газар нь сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын хувьд дараах эрх эдэлнэ.

4.1.1 Харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбогдсон асуудлыг Эрүүл мэндийн газар болон нутгийн захиргааны байгууллага, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

4.1.2 Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд нийгмийн эрүүл мэндийн болон сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар аж ахуйн нэгж байгууллага, гэр бүл, хувь хүнд мэргэжлийн зөвлөгөө, зааварчилга өгөх;

4.1.3 Үндсэн зорилго, зорилт, чиг үүргийн хүрээнд төрийн болон төрийн бус байгууллага, иргэнд шаардлага тавих эрхтэй;

4.1.4 Өөрийн чиг, үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах бүтэц, хүний болон материаллаг нөөцийг бүрдүүлэх, зарим төрлийн үйлчилгээг төлбөртэйгээр үзүүлж, холбогдох хууль, тогтоомж, дүрэм журмын дагуу захиран зарцуулах;

4.1.5 Судалгаа шинжилгээг хөгжүүлэн, орон нутаг, бүс, үндэсний болон олон улсын эрдэм шинжилгээний хурал, сургалт, семинарт оролцох;

4.1.6 Үндсэн үйл ажиллагаанаас гадна судалгаа шинжилгээ дүгнэлтийн хүрээнд төсөл хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх, Олон улсын болон донор байгууллагын тусламж, дэмжлэг авах;

4.1.7 Тусламж, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй, стандартын дагуу үзүүлэхэд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, хөрөнгө оруулалтын асуудлаар төрийн захиргааны төв байгууллагад нотолгоонд суурилсан санал боловсруулан тавьж шийдвэрлүүлэх;

4.1.8 Хууль, тогтоомжоор олгогдсон бусад эрх;

4.2 “Жаргалтай амьдрал сэтгэц, нийгмийн сэргээн засах эмчилгээний төв” ОНӨААТҮГ нь дараах үүрэг хүлээнэ.

4.2.1 Сэтгэц, нийгмийн сэргээн засах эмчилгээний чиглэлээр улсын хэмжээнд мөрдөгдөх хууль, дүрэм, стандарт, эмнэлзүйн удирдамжийн хэрэгжилтийг хангах;

4.2.2 Бусад эрүүл мэндийн байгууллагаас холбогдох журмын дагуу шилжүүлсэн

өвчтөнд сэтгэц, донтолтын төрөлжсөн мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх;

4.2.3 Сэтгэц, донтолтын тусламж үйлчилгээг сайжруулах, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга хэмжээний санал боловсруулан эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад танилцуулах;

4.2.4 Тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, аюулгүй байдлыг хангах үүднээс зардлын хувьд үр ашигтай оношилгоо, эмчилгээний дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх;

4.2.5 Сэтгэцийн эрүүл мэнд, архины шалтгаант эмгэгийн чиглэлээр олон нийт болон зорилтот бүлгийн хүн амын дунд урьдчилан сэргийлэх ажиллагааг зохион байгуулах;

4.2.6 Хүн амын дунд сэтгэцийн шалтгаант эмгэгийн түвшин, тархалт, нас баралт, архинд донтох эмгэгийг судлах тандалтын тогтолцоог бий болгон мэдээний сан бүрдүүлж, төрийн захиргааны төв байгууллага, хүн ам, бусад холбогдох этгээдийг мэдээллээр хангах;

4.2.7 Үйл ажиллагаандаа мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэн цахим төв, цахим бүртгэл, цахим өвчний түүхийг ашиглах нөхцлийг бүрдүүлэх, алсын зайн анагаах ухааныг хөгжүүлэх;

4.2.8 Сэтгэцийн эрүүл мэнд, донтох эмгэгийн тусламж, үйлчилгээний чиглэлээр эмнэлзүйн судалгаа шинжилгээ хийх;

4.2.9 Эрүүл мэндийн талаар гарсан хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, мэргэжлийн дээд шатны байгууллага, нутгийн захиргааны байгууллагын шийдвэр, улсын байцаагчийн шаардлагыг биелүүлэх;

4.2.10 Газрын барилга байгууламж, оношилгоо, эмчилгээний багаж хэрэгсэл болон холбогдох бусад тоног төхөөрөмж, техник хэрэгсэл нь эрүүл ахуйн болон стандартын шаардлага хангасан, ажилтны хөдөлмөрийн онцлогт тохирсон, аюулгүй ажиллагааны нөхцөл, шаардлагыг хангасан байх;

4.2.11 Үйл ажиллагааныхаа тайлан мэдээг хугацаанд нь гаргах, бусад байгууллага, иргэнийг эрүүл мэндийн асуудлаар өөрийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр хангах;

4.2.12 Үндсэн зорилго, чиг үүргийн хэрэгжилтийг хангах, эрчимжүүлэх хүрээнд эрүүл мэндийн үзлэгийн кабинет, мэргэжлийн зөвлөгөө өгөх нэгж, бусад зохион байгуулалтыг хийж мэргэжил, арга зүйгээр хангах;

4.2.13 Ажиллагсдын мэдлэг мэргэжлээ дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлж, нийгмийн баталгааг хангах, ажлын байрны нөхцлийг сайжруулах талаар хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэн санаачилгатай ажиллах;

4.2.14 Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын хүрээнд алсын хараа, хэтийн зорилгоо тодорхойлж, стратеги төлөвлөгөө, байгууллагын дотоод журам, тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх;

4.2.15 Тусламж, үйлчилгээний талаарх үйлчлүүлэгчдийн санал, хүсэлт, гомдлыг шуурхай хүлээн авч шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэх, санал гомдолд дүн шинжилгээ хийж, залруулах арга хэмжээг үйл ажиллагаандаа тусган ажиллах;

4.2.16 Өөрийн үйл ажиллагааны онцлогыг тусгасан эрсдлийн удирдлагын журам боловсруулан, хэрэгжүүлэх;

4.2.17 Санхүү төсвийн нээлттэй, ил тод зарчмыг баримтлан санхүүгийн нөөцийн төлөвлөлтийн бодит, нотолгоонд тулгуурласан байдлыг хангаж ажиллах;

4.2.18 Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, сахилга хариуцлагын хэм хэмжээг мөрдүүлж ажиллах;

4.2.19 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас гарсан албадан эмчилгээний тогтоолыг хэрэгжүүлэх;

4.2.20 Ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагатай хамтран ажиллах, гадны улс орны шинэ тутам үйлчилгээг судалж нэвтрүүлэх;

4.2.21 Хууль тогтоомжид заасан бусад үүрэг;

#### **Тав. Газрын бүтэц, зохион байгуулалт**

5.1. Төвийн удирдлагын тогтолцоо нь дарга, түүний дэргэдэх Удирдлагын зөвлөлөөс бүрдэж, ажиллах журам тогтооно.

5.2 Удирдлагын зөвлөл нь 9 хүний бүрэлдэхүүнтэй байх ба аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогч, Цагдаагийн газрын Олон нийттэй харилцах тасгийн дарга, газрын дарга, нягтлан бодогч, аймгийн Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн тэргүүн зэрэг 5 хүнийг дүрмээр тогтоож, үлдсэн 4 гишүүнийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоох бөгөөд бүрэлдэхүүнээс Удирдах зөвлөлийн даргыг сонгоно

5.3. Газрын даргын дэргэд эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн баг, чанарын баг, халдвар хяналтын багийг ажиллуулж болно. Чиг үүргийг газрын даргын тушаалаар батлана

#### **Зургаа. Газрын даргын эрх, үүрэг**

6.1. Газрыг гадаад, дотоодын хамтын ажиллагаанд бүрэн хэмжээгээр төлөөлөх, үйл ажиллагааны үр дүнг хариуцах,

6.2. Газрын бүтэц, зохион байгуулалт, зориолго, зорилт, үйл ажиллагааны чиглэл, чиг үүргийг тодорхойлох, байгууллагын дотоод журам, эрсдлийн удирдлагын журам

ойрын болон хэтийн стратеги төлөвлөгөө, байгууллагын хөгжлийн хөтөлбөрийг боловсруулах батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

6.3. Батлагдсан төсөв, бүтэц орон тооны хязгаарт багтаан төвийн орон тоо, ажиллагсдын цалин хөлсийг тогтоох;

6.4. Эмч, мэргэжилтэн, ажилтнуудыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу томилох, чөлөөлөх;

6.5. Байгууллагын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан, биелэлт, тайланг хамт олны хурлаар хэлэлцүүлэн олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээллэх;

6.6. Ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтыг батлах, хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх, урамшуулах, сахилгын шийтгэл ногдуулах, гэрээг цуцлах;

6.7. Төсвийн ерөнхийлөн захирагчтай жил бүр төвийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгуулж, биелэлтийг хангаж, аймгийн Засаг даргын Тамгын газарт тайлагнах, мэдээлэх;

6.8. Удирдах ажилтны ёс зүйг чанд сахиж, авилга, ашиг сонирхолын зөрчлөөс ангид ажиллах;

6.9. Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн үнэн зөв байдлыг хариуцах;

#### **Долоо. Санхүүжилт**

7.1. Санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

7.1.1 Улсын төсөв

7.1.2 Эрүүл мэндийн даатгал;

7.1.3 Орон нутгийн төсөв;

7.1.4 Үндсэн (хууль тогтоомжоор зөвшөөрсөн төлбөртэй тусламж, үйлчилгээний орлого) ба үндсэн бус үйл ажиллагааны орлого (байр, техник хэрэгсэл, бусад эд хөрөнгөө түрээслүүлсний орлого, бусад хууль тогтоомжид нийцүүлэн олсон орлого гэх мэт);

7.1.5 Төсвийн тухай хуульд заасан журмын дагуу Монгол Улсын болон гадаадын иргэн, хуулийн этгээд, хувь хүнээс авсан хандив, тусламж, сайн дурын үндсэн дээр иргэнээс тус төвд оруулсан хөрөнгө оруулалт;

7.1.6 Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;

7.1.7 Хууль, тогтоомжид заасан бусад эх үүсвэр.

7.2. Төвийн төсөв, санхүүжилттэй холбоотой үйл ажиллагаа нь Төсвийн тухай, Эрүүл мэндийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, орон нутгийн удирдах байгууллага болон бусад хууль тогтоомжоор зохицуулагдана.

7.3. Үйл ажиллагааныхаа хүрээнд төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулна.

#### **Найм. Гадаад, дотоодын хамтын ажиллагаа**

8.1. Газрын дарга, ажилтнуудыг гадаад, дотоодод сургах, мэргэжил дээшлүүлэх, сургалтад хамруулах асуудлыг Удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэрийн дагуу албан томилолтоор ажиллуулах эсэхийг аймгийн Засаг дарга шийдвэрлэнэ.

8.2. Ижил чиг, үүрэг бүхий гадаадын лавлагаа төвүүдтэй хамтын ажиллагааг өргөжүүлэн тусламж, үйлчилгээг сайжруулах, байгууллага болон хүний нөөцийг чадавхижуулах чиглэлээр хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, харилцан туршлага солилцох.

8.3. Газар нь хувь хүн, гэр бүл, хамт олонд эрүүл мэндийн боловсрол олгох, хүн амын дунд эрүүл мэндийг дэмжих орчныг бүрдүүлэх талаар бусад байгууллагатай хамтран ажиллаж, өөрийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр хангах;

8.4. Газар нь өөрийн орны болон гадаадын төрийн, төрийн бус, хувийн хэвшлийн байгууллага, иргэдтэй хамтран ажиллах, шаардлагатай тохиолдолд харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулж болно.

8.5. Газар нь Эрүүл мэндийн газар болон бусад холбогдох байгууллагатай шууд харилцаж, эрүүл мэндийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг биелүүлэх ажлыг зохион байгуулахдаа чиглэл, үүрэг, зөвлөмж авч үйл ажиллагаагаа уялдуулан ажиллана.

8.6. Газар нь сум, орон нутгийн захиргааны байгууллагын хүсэлт, судалгаанд үндэслэн архины хамаарал бүхий иргэдийг эмчилгээнд хамруулна.

8.7. Архины дуршил бууруулах эмийн эмчилгээнд удаан хугацаанд хамрагдах иргэдийг сумын Эрүүл мэндийн төвтэй хамтран эмчийн хяналтан дор байлгана.

8.8. Газар нь өөрийн эрхлэх асуудлаар аймгийн Эрүүл мэндийн газар, сумдын эрүүл мэндийн төвүүд, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэй шууд харилцана.

#### **Ес. Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах**

9.1. Аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрээр дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулна.